

Аудитын нэр:

**МӨСТ СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2015 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ**



Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаагаа бүрэн ханган хэрэгжүүлэн ажилласан боловч, орон нутгийн татварын орлогыг бүрэн бүрдүүлээгүй, бараа материалыг өндөр үнээр худалдан авсан байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны бүртгэлд тавих хяналт сул, хүүхэд хүмүүжих хөгжих таатай орчинг бүрдүүлэн ажилласан байна.

Ховд хот

2016 оны 10 сар



Аудитын тайлан

АГУУЛГА

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Ховд аймгийн Аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Л.Галбадрах Аудитын менежер А.Цэцэгсүрэн Ахлах Аудитор Д.Хишгээ 2016 -10- 28 Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432736 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын тамгын газар	Товчилсон үгийн тайлбар.....2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт.....3-4 Аудитын дүн.....5 БҮЛЭГ -1 Орон нутгийн байгууллагуудын талаар Дүгнэлт: Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж сум орон нутгийнхаа өнгө үзэмжийг сайжруулан томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хийсэн байна. Орон нутгийн татварын орлого тасарсан, СХСангийн зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бараа материалыг жишиг үнээс өндөр үнээр бэлтгэсэн байна. 5-10 БҮЛЭГ- 2 <u>Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын талаар</u> Дүгнэлт: Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаагаа бүрэн ханган хэрэгжүүлэн ажилласан боловч, орон нутгийн татварын орлогыг бүрэн бүрдүүлээгүй, байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны бүртгэлд тавих хяналт сул, хүүхэд хүмүүжих хөгжих таатай орчинг бүрдүүлэн ажилласан байна.....10-16 Ерөнхий дүгнэлт..... 16 Зөвлөмж.....16-17 Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Хавсралт 1 Актын товчоо



Товчилсон үгийн тайлбар

ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их Хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТЭЗ	Төсвийн ерөнхий захирагч
ХБГ	Хүлээгдэж буй гүйцэтгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МЭҮТ	Мал эмнэлэг үржлийн тасаг
ЭЭС	Эмийн эргэлтийн сан



Аудитын тайлан

МӨСТ СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН
ЗАРЦУУЛАЛТАНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН
2016.10.28 Улаан толгой

Аудитын код: ХО-1/2016/-23-ГА

Аудитын талаарх товч мэдээлэл: Мөст сум нь 3033 гаруй хүн амтай, 176,4 мянган толгой малтай, 394,2 мянган га газар нутагтай, аймгийн төвөөс 180 км, улсын нийслэл Улаанбаатараас 1300 гаруй км алслагдсан, зам харгуй сайтай.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ИТХ-тай, төрийн захиргааны байгууллага ЗДТГазар, нийгмийн үйлчилгээний салбар Хүн эмнэлэг, 12 жилийн ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг төсөвт байгууллагуудтай, ХААН, Төрийн банк, Холбоо 52 аж ахуйн нэгжтэй. Эрчим хүчний байнгын эх үүсвэрт холбогдон төрийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх үүрэгтэйгээр ажиллаж байна.

Аудит хийх бүрэн эрх үндэслэл: Аймгийн ИТХ, ЗД-ын захиалга, Аймгийн Аудитын газраас аймагт нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний гэрээ, Тэргүүлэх аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдаж, ахлах аудитор Д.Хишгээ, аудитор Д.Мөнхтулга, Д.Эрдэнэцэцэг, шинжээч Д.Дамчуубалжир нар 10 дугаар сарын 25-нээс 28-ныг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргав.

Аудитын зорилт: Мөст сумын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж дүнг аймаг, сумын ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, Засаг дарга, холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулж холбогдох шийдвэр гаргуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийг нарийвчлан авч үзэж үнэлэлт дүгнэлт өгнө.Үүнд:

- Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээгээр хүлээсэн үүргээ тоо, чанарын хүрсэн байх түвшинг ханган биелүүлсэн эсэх
- Төсвийн байгууллагуудын төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын явцад нөөцийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах зарчим хэрэгжсэн эсэх
- Хөрөнгө оруулалтыг зохистойгоор хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ: Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд төсвийн захирагчдаас 2015 онд сумын Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ, уг гэрээг дүгнэсэн тухай илтгэх хуудас, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн тайлан, төрийн албан хаагчдийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт үр дүнгийн тайлан, төсвийн байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн тайлан тэнцэл, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх санхүүгийн баримт материал, өмч хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэл, өдөр тутмын банкны хуулга, касс, харилцахын гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн туслах, журналууд, дэлгэрэнгүй бүртгэлүүд зэрэг баримт материалыг хамрууллаа.



Аудитын тайлан

Аудитын арга зүй: Аудит хийх явцад гүйцэтгэлийн аудитын болон хяналт шалгалтын арга зүй, өмнөх төсвийн жилийн гол үзүүлэлтүүдийн зэрэгцүүлэлт хийж шинжлэх, санхүүжилт, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг дүнгээс хөөн шалгах, харилцагч байгууллагатай тооцоог тулган шалгах, баримтаас хөөн шалгах, бусад орлого болон тайланд тусгагдаагүй ажил гүйлгээнд хэсэгчилсэн, түүвэр шалгалтуудыг хийж дүнг тулгах зэрэг аудитын оновчтой тохирох горимуудыг хэрэгжүүлсэн болно. Аудитын хугацаанд сумын ЗДТГ-т саналын хайрцаг ажиллуулсан бөгөөд ямар нэгэн санал ирээгүй байна. Байгууллагын нийт ажилчдын 58 хувь буюу 81 хүнээс нэргүй санал асуулга авч аудитад ашиглалаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Төрийн Аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль, Татварын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиуд, Хөдөлмөрийн хууль, Холбогдох тогтоол, журам заавар, захирамж, тушаал зэргийг шалгуур болгон ашиглав.

Аудитын стандартын талаархи мэдэгдэл: Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналтын шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталсан бөгөөд аудитын дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээлэлийг ажлын баримт материалд хавсаргав.

АУДИТЫН ДҮН:

Бүлэг 1: Орон нутгийн байгууллагуудын талаар:

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө биелээгүй байгаа дүгнэлт хийж орлогын нөөц боломжийг нэмэгдүүлэн ажиллах шаардлагатай байна.

Тус сум Татварын болон татварын бус орлогоор 65,1 сая төгрөгний төгрөгний орлогын төлөвлөгөөтэйгээс, гүйцэтгэлээр 47,0 сая төгрөгний орлого бүрдүүлж 18,1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөгөө тасалсан байна. Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: аж ахуй эрхэлсний орлогын албан татвар 5,5, үйл ажиллагааны орлого 6,7, улсын тэмдэгтийн хураамж 0,4, ой 0,8, ус ашигласны төлбөр 0,1, ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж 0,9, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,9 сая төгрөгөөр тус тус тасалж 9 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 16,7 сая төгрөгөр тасарч, орлого бүрдүүлэх нөөц боломжоо алдсан байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:

Татварын төрөл	НИЙТ ОРЛОГО		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Нийт орлого	65.1	47.0	18.1
Урсгал орлого	65.1	47.0	18.1
Татварын орлого	62.5	45.7	16.7
Хүн амын орлогын албан татвар	19.9	7.1	12.8
Орлогыг тодорхойлох боломжгүй	0.9	0.3	0.6
Хувиараа аж ахуй эрхэлсний	6.5	1.0	5.5
Үйл ажиллагааны орлого	12.5	5.8	6.7
Өмчийн татвар	0.4	0.9	(0.5)
Бууны	0.4	0.9	(0.5)
Бусад орлого	42.2	37.7	4.5



Аудитын тайлан

Тэмдэгтийн хураамж	2.0	1.6	0.4
Ойн нөөц ашигласны төлбөр	0.8	-	0.8
Ус рашаан	0.1	-	0.1
Ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж	35.0	34.1	0.9
Хог хаядлын үйлчилгээний хураамж	2.5	0.6	1.9
Байгалийн ургамал ашигласны	1.0	0.4	0.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.8	1.0	(0.2)
Татварын бус орлого	2.6	1.3	1.3
Төсөвт байгууллагын орлого	0.6	0.3	0.3
Хүү торгуулийн орлого	2.0	1.0	1.0

Орон нутгийн төсөвт байгууллагууд аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 443,4 сая төгрөгийг авахаас 405,3 сая төгрөгийг авч 37,8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг дутуу авчээ.

Татварын улсын байцаагч: 2015 оны сумын нийт татварын орлого 184,3 сая төгрөгний орлогын төлөвлөгөөтэйгээс 177,9 сая төгрөгний орлого бүрдүүлж 6,4 сая төгрөгөөр тасарчээ. Татварын хэлтсийн даргатай байгуулсан 2015 оны бүтээгдхүүн ажил үйлчилгээний гэрээгээ “С” буюу 78,1 оноогоор биелүүлсэн байна. Суманд бүртгэлтэй 56 ААН байгаа бөгөөд дээрх ААН-үүдийн орлогын татварт төлөлтийг авч үзэхэд улсын төсөвт 20,0 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Хужирт багийн Нарийн дав гэдэг газар “Бодонч их бүрд” нөхөрлөл вольвром чулууны олборлолт явуулж 2015 онд түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрт 500,0 мянган төгрөг төлсөн

Илрүүлэлт: Мөст сумын төвд 2015 онд Хаш-өргөө компанийн 100 хүүхдийн дотуур байр, БИССЭТ компанийн барисан 120 хүүхдийн цэцэрлэгт шинээр баригдсан бөгөөд тус компаниудад түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрт Хаш өргөө компанид 872,0, Биссет компанид 1960,0 бүгд 2832,0 мянган төгрөг төлөхөөс хаш өргөө компани 200 мянган төгрөг төлж, тус суманд бүтээн байгуулалтын ажил хийсэн, Биссет компани 1960,0 мянган төгрөг төлөөгүй байна.

Тус сумын хэмжээнд бүртгэлтэй 418 авто тээврийн хэрэгсэл байгаа боловч үүнээс татвар төлж байгаа авто тээврийн хэрэгсэл байгаа бөгөөд 131 авто тээврийн хэрэгсэл байхгүй мөртлөө татварын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

“Лото-блок” компани сумын төвд зам, гэрэлтүүлэг тавьсан бөгөөд энэ ажлын түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр төлөөгүй байна.

Нийгмийн даатгалын байцаагч: Нийгмийн даатгалын багц хууль, Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын хэлтсийн даргатай 2015 онд 2 ангид 11 бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан гэрээгээ В үнэлгээтэй дүгнүүлэн ажиллаж тайлангийн хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэмжинд нийт 298 иргэн, оршуулгын тэтгэмж 12 иргэн, жирэмсэн амаржсаны тэтгэмж 14 иргэн, ХЧТА-ны тэтгэмж 17 иргэн, бүгд 341 иргэнд 1142,6 сая төгрөгийн зарлага гаргаж, шимтгэлийн орлогоор 276,2 сая төгрөгийн орлого бүрдүүлж тэтгэвэр, тэтгэмжид зарцуулжээ.



Аудитын тайлан

Тайлангийн хугацаанд ААН 4, 27 иргэнд өндөр насны тэтгэвэр, иргэнд тахир дутуугийн тэтгэмж, тэжээгчээ алдсаны тэтгэмжийг бүрдүүлэн шинээр тогтоож олгосон. Сайн дурын даатгалд 22,8 сая төгрөг, иргэн хамруулж, ЭМД-д 5,1 сая төгрөг, нөхөн даатгалт 3,0 сая төгрөгийн орлогыг оруулан ажилласан байна.

Халамжийн улсын байцаагч: 2015 онд орон нутгийн төсвөөс 110,0 сая төгрөгийн санхүүжилт олгож халамжийн хуульд заасны дагуу 20 гаруй нэр төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон байна.

Аудитын шалгалтаар амжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэрээр хүнсний талон олгосон ч холбогдох анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй байгаад халамжийн хууль болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу холбогдох баримтыг бүрэн бүрдүүлсний дагуу мөнгөн тэтгэмжийг олгож байхыг зөвлөлөө.

1.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар

Тус суманд үйл ажиллагаа явуулж сумын орон нутгийн байгууллагуудад 450,0 сая төгрөгийн зардал гаргаснаас Халамжийн зардалд 42,3 хувь, ЗДТГ-ын үйл ажиллагаанд 32,5 хувь, Багийн үйл ажиллагаанд 11,8 хувь, ИТХ-ын үйл ажиллагаанд 8,6 хувь, Мал эмнэлэгийн урьчдиглан сэргийлэх арга хэмжээнд 3,7 хувь, нөөц хөрөнгө, ахмадын үйл ажиллагаанд 0,9 хувь тус тус зарцуулагджээ.

Төсвийн орлого			Санхүүгийн дэмжлэг			Нийт урсгал орлого			Урсгал орлогын өөрчлөлт	Мөнгөн хөрөнгө			Төсвийн зарлага		Зардлын өөрчлөлт
төл	гүй	Давсан орлого	төл	гүй	Санхүүгийн дэмжлэгийн аанчлалт	төл	гүй	гүй		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	өөрчлөлт	төл	гүй	
65.1	47.7	17.4	443.3	405.4	37.9	508.3	453.1	55.3		58.6	2.2	56.5	508.3	468.6	39.8

Энэ аудитын шалгалтанд 6 төсвийн байгууллага, хувийн 2 мал эмнэлэг, улсын байцаагч, мэргэжилтэнүүд 5 баг хамрагдлаа. Дээрхи шалгагдсан байгууллага албан тушаалтнуудын үйл ажиллагааны үр дүн төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар товч танилцуулвал:

1.3. Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаар :

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 10 бүлэгт 76 ажил хийх ажлын төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд сум орон нутгийн эдийн засаг нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд сумын засаг дарга, ЗДТГ, төрийн үйлчилгээний байгууллагын хариуцах чиг үүргийг тодорхой болгож, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч 2015 онд ИТХ-ын хуралдааныг 2 удаа хийж дэвшүүлсэн зорилтоо ханган биелүүлж, тэргүүлэгчдийн хуралдааныг 11 удаа хийж ИТХТ-ын 76 тогтоол, 11 тэмдэглэл гаргасан байна. Багийн ИТХ-ийг 14 удаа хуралдуулж, тайлан мэдээлэл хийх, ОНХСангаар хийх бүтээн байгуулалтын ажлаа хэлэлцүүлж эрэмблүүлэх зэрэг цаг үеийн ажил хэлэлцдэг.

ИТХ нь бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд жил, улирлаар хийх ажлаа төлөвлөн төлөвлөсөн ажлаа 90,5 хувиар ХОА- /2016/ 23 - ГА



Аудитын тайлан

биелүүлжээ. Дээрхи төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн төсвөөс 47,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас, гүйцэтгэлээр 47,5 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг авч батлагдсан төсөвт зардалдаа багтаан үйл ажиллагаандаа явуулсан.

Аудитаар ИТХ-тай холбоотой зөрчил, төлбөр илэрсэнгүй.

1.4. Засаг даргын Тамгын газар, багийн үйл ажиллагааны талаар:

Сумын ЗДТГ нь аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин бизнест ээлтэй, иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах, аж амьдралаа дээшлүүлэх үндсэн зорилгоо чиглүүлэн ажилласан байна.

Сумын Засаг даргын 2012-2016 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 90,5 хувьтай, 2015 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 85,4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Төрийн үйлчилгээг ард иргэд, албан байгууллагуудад ил тод шуурхай хүргэх, төр ард иргэдийн холбоог бэхжүүлэх зорилт тавин ажилласан. Нийт 18 орон тоотой ажиллахаас, гүйцэтгэлээр 19 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

ЗДТГ-ын дарга болон ЗДТГ-ын ажилчид тайлант онд бүтээгдхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээ байгуулж ажлыг дүгнэн үр дүнгийн нэмэгдлийг 1 удаа олгожээ. 2015 онд 194,0 мянган толгой малтайгаас давхардсан тоогоор мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамрагдсан. 2015 онд 11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг үйлчилгээ хийлгэсний санхүүжилтэнд 17,5 мянган бод, 155,7 мянган богийг хамруулж 4 хувийн мал эмнэлэг үржлийн нэгжид 21,5 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Тайлант онд тус суманд Нутгийн зөвлөл, хувь хүмүүсээс Дууны хөшөө-57,0, цэцэрлэгт хүрээлэн 130,0 сая төгрөгөөр хийсэн байна. АХБ-ны санхүүжилтээр 10ш хүлэмж 33,0, Гүний худаг 1 ш 34,0 сая төгрөгний хөрөнгийг данс бүргэлдээ тусгасан байна.

2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд 319,2 сая төгрөг зарцуулахаар төсвийг нь баталж гүйцэтгэлээр 304,7 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 14,5 сая төгрөгөөр дутуу авч, өөрийн орлогын 0,3 сая төгрөгийн орлогыг тасалсан.

2014 онд сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зардалд 4,5 сая төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 3,2 сая зарцуулж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 24,1 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 21,5 сая төгрөг, ахмадын хороонд 0,8 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 0,8 сая төгрөг олгож батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулжээ.

Тус сум нь хөдөөгийн 4 төвийн 1 бүгд 5 багтай нийт 3033 хүн амд багийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Багийн дарга нар тайлант онд багийн Засаг дарга нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ байгуулан жилийн эцэст ажлаа дүгнүүлэн, тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан ажилласан байна.

 Орон нутгийн төсөвт байгууллагад 2015 онд 20 тн нүүрсийг аймгийн Төрийн сангаас сар бүр гаргадар жишиг үнээс өндөр үнээр бэлтгэсэн



Аудитын тайлан

- ✚ Эрх зүйн ажилтанд 0,5 сая төгрөгний нууцын нэмэгдэл, нягтлан бодогчидод ажил хавсран гүйцэтгэсний 20 хувийн нэмэгдэл цалин олгосон

1.5. Сум хөгжүүлэх сангийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн № 134 тогтоолын дагуу жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, өмнөх жилийн зээлийн ашиглалт, зээл авах хэрэгцээ шаардлага зэргийг харгалзан Мөст суманд 2011 оны 60,0 сая, 2013 оны 110,0 сая, 2014 онд 50,0, 2015 онд 50,0 бүгд 270,0 сая төгрөг хувиарласан байна.

Тус суманд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор сумын Засаг даргаар ахлуулсан 7 хүний бүрэлдхүүнтэй төсөл сонгон шалгаруулах зөвлөл байгуулжээ. Тус зөвлөлийн хурлаар ард иргэд, аж ахуйн нэгжээс нийт 2011 онд 10 иргэн, ААН-д 60,0 сая, 2012 онд 10 иргэнд 18,9 сая, 2013 онд 16 иргэн, ААН-д 118,4 сая 2014 онд 11 иргэн, ААН-д 53,5, 2015 онд 11 иргэн, ААН-д бүгд 59,1 сая бүгд 58 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 309,9 сая төгрөгийн зээлийг санхүүжилт болон зээлийн эргэн төлөлтөөс олгожээ.

СХСангийн дансанд оны эхэнд 46,7 сая төгрөгний мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 15,3, хүүгийн төлбөрөөс 1,9, бусад орлогоор 0,5 сая бүгд 17,7 сая төгрөгний орлого бүрдүүлж, 58,6 сая төгрөгийн зээл олгосон байна.

- ✚ 2011 онд олгосон 60,0 сая төгрөгнөөс 4 зээлдэгчтэй холбоотой 26,0 сая, 2012 онд олгосон 18,9 сая төгрөгний зээлээс 4 зээлдэгчтэй холбоотой 1,8, бүгд 8 иргэнтэй холбоотой 27,8 сая төгрөгний зээлийн үлдэгдэлтэй байна.
- ✚ Дээрхи 8 иргэн, аж ахуйн нэгжийг Булган сумын Сум дундын 2 дугаар шүүхэд өгч, шүүхийн шийдвэр гаргуулан ажилласан байна. 2013 онд олгосон зээлнээс 5 иргэнтэй холбоотой 36,6 сая төгрөгийг эргэн төлүүлэхээр шүүхэд өгсөн байна.
- ✚ 2011-2015 оны хооронд нийт 58 иргэн аж ахуйн нэгжид олгосон зээлнээс 27 иргэн аж ахуйн нэгж зориулалтын дагуу, үлдэх 31 иргэн аж ахуйн нэгж зориулалтын бус ашигласан байна. **Үүнээс үзэхэд СХСангийн зээлийн эргэн төлөлт, ашиглалт хангалтгүй байна.**

1.6. Орон нутгийн хөгжлийн сангийн талаар

2015 онд ОНХС-д нийт 141,5 сая төгрөг батлагдсанаас 100,0 сая төгрөгийн санхүүжилт ирж 41,5 сая төгрөгийн санхүүжилт орлого тасарснаас шалтгаалан ирээгүй байна. Мөст сумын ИТХ хуралдаж иргэдийн санал авч эрэмбэлэн нийт 10 төсөл арга хэмжээг санхүүжүүлжээ. Нийт хийгдсэн 15 ажлыг шууд гэрээ байгуулжээ.

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	төл	Гүй	зөр
1.1.1	Хөрөнгө оруулалтын дүн	99.5	67.9	31.6
1.1.1	Багийн төв засвар /Цэцэг гол /	10.0	10.0	-
1.1.2	Гудамжны гэрэлтүүлэг нэмэх, явган зам тавих	44.0	33.1	10.9
1.1.3	Баяр наадмын зардал	10.0	5.0	5.0
1.1.4	Нохой устгах	1.0	0.3	0.7
1.1.5	Багийн төв засвар /Давст /	15.0		15.0
1.1.6	Сургуулийн хашаа	19.5	19.5	-



Аудитын тайлан

1.2	Тоног төхөөрөмж	4.0	-	4.0
1.2.1	Тавт, Цагаан хөтөлд самбар босгох	4.0	-	4.0
ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ		38.0	32.1	5.9
1.3.1	Иргэний танхим байгуулах тохижуулах	5.0	-	5.0
1.3.2	Соёлын төвийн музей шинэлэн хорго	3.0	3.0	-
1.3.3	Авъяас хөтөлбөр	5.0	-	5.0
1.3.4	Болзошгүй эрсдэл	10.0	9.1	0.9
1.3.5	Цэцэрлэгийн тоглоомын талбай	5.0	-	5.0
1.3.5	Дархан, Эрдэнэт хотуудад сум суртчилах	5.0	5.0	-
1.3.6	Халуун усны цооног засварлах	2.0	2.0	-
1.1.7	Эрчим хүчний шугам засвар	3.0	3.0	-
1.1.8	Хатуу хучилттай замын инженери йн нарийвчласан зураг хийлгэх	-	10.0	(10.0)
ДҮН		141.5	100.0	41.5

ДҮГНЭЛТ: Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж сум орон нутгийнхаа өнгө үзэмжийг сайжруулан томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг хийсэн байна. Орон нутгийн татварын орлого тасарсан, СХСангийн зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, бараа материалыг жишиг үнээс өндөр үнээр бэлтгэсэн байна.

Бүлэг 2. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын талаар

Тус суманд 12 жилийн сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, соёлын төвүүд тусгай зориулалтын шилжүүлгээр 1376,0 сая төгрөгийн санхүүжилт авч, 1,3 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэн үйл ажиллагаагаа явуулжээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд	Өөрийн орлого		Санхүүгийн дэмжлэг		Нийт урсгал орлого		Урсгал орлогын өөрчлөлт	Төсвийн зарлага		Зардлын өөрчлөлт
	төл	гүй	төл	гүй	төл	гүй		төл	гүй	
Сургууль	0.5		792.1	771.8	792.6	771.8	20.8	792.6	771.8	20.8
Цэцэрлэг			185.1	181.4	185.1	181.4	3.7	185.1	181.4	3.7
Эрүүл мэндийн төв	1.9	0.7	373.5	368.0	375.4	368.7	6.7	375.4	368.7	6.7
Соёл	5.0	0.6	52.4	54.8	57.4	55.4	2.0	57.4	55.4	2.0
Нийт дүн	7.4	1.3	1,403.1	1,376.0	1,410.5	1,377.3	33.2	1,410.5	1,377.3	33.2

2.1. Сумын 12 жилийн бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны талаар:

Мөст сумын сургууль нь 2015 оны хичээлийн жилд 47 багш, 35 ажилчин, 26 бүлэгт 617 сурагчидтайгаар “Боловсон зөв харилцаатай, бие бялдарын эрүүл хөгжилтэй, бие дааж бүтээлчээр суралцах чадвартай хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилготойгоор сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулжээ.

2015 онд тус сургуульд магистр 18, бакалавр 28, дипломын 1, мэргэжлийн зэргийн хувьд тэргүүлэх 5, арга зүйч 1 ажиллаж 2014-2015 оны хичээлийн жилд сурлагын стандарт хангалт зохих түвшинд хүргэх, АВ-48 эзлэх хувийг урьд жилээс ахиулах, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог 500-д хүргэх зэрэг зорилтуудыг тус тус дэвшүүлж уг зорилтын хүрээнд Ерөнхий шалгалтын үнэлгээг 515 оноо авч өмнөх оноос 0,3 хувиар, АВ-ийн эзлэх хувь 1,3 хувиар тус тус өссөн



Аудитын тайлан

байна. Ерөнхий менежер нь 2015 онд үр дүнгийн гэрээгээ 85 оноогоор “В” үнэлгээтэй дүгнүүлжээ.

Тус сургууль нь “Авьяас” “Ном” хөтөлбөрүүдийн хүрээнд сурагчдын авьяас чадварыг нээх зорилгоор 20 төрлийн сонгон хичээллүүлэн сурагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Хүүхэд хөгжлийн төв, дотуур байранд 6 настай сурагчдын сурч хөгжих танхимыг тохижуулсан байна. Мөн дотуур байранд сурагчдын үс засах өрөө, эрүүл мэндийн өрөө, эцэг эхийн өрөө, амьдрах ухааны төв, халуун усны өрөө тохижуулан 2015 онд шинэ дотуур байр ашиглалтанд орон үйл ажиллагаагаа явуулж байна.

Малчдын хүүхдийг сурч боловсрох таатай орчин бүрдүүлэх зорилгоор 100 хүүхэд авах хүчин чадалтай дотуур байранд 100-110 гаруй хүүхдийг дотуур байраар ханган сурган хүмүүжүүлэн байрны хүүхдүүд болон эцэг эхчүүдийн дунд “Дотуур байр нэг өдөр”, “Эцэг эхийн нэг өдөр” гэсэн сургалт, өдөрлөг зохион байгуулан эцэг эхийн оролцоогоор өрөө тасалгааг тохижуулсан байна.

2015 онд ОНХСангийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтаар сургуулийн бага хэмжээний анги танхим тохижуулж тоног төхөөрөмжөөр хангасан, 0,8 сая төгрөгөөр дотуур байр, спорт заалны гэрэлтүүлгийн асуудлыг шийдвэрлэсэн. Яамны хөрөнгө оруулалтаар 74,2 сая төгрөгийн өртөг бүхий гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж, ширээ сандлаар хангаж сурагчдын ая тухтай орчинд сурч амьдрах орчинг бүрдүүлэн ажилласан байна.

2014-2015 онд Улсын болон аймаг орон нутгийн чанартай олимпиад, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон төдийгүй 2015 оны ажлаараа аймгийн 24 сургуулиас 8-р байранд шалгарсан байна.

БСШУ, ЭМ-ийн сайдын 2006 оны 379/341 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу үдийн цай хөтөлбөрийг зохион байгуулж тайлангийн хугацаанд 1-5 дугаар ангийн 5 бүлэгт нийт 248 хүүхэд буюу 39500 хүүхэд өдрийг “Үдийн цай хөтөлбөр”-т хамруулсан байна. Үдийн цай хөтөлбөрт нийлүүлэгдэж буй бүтээгдэхүүн, дотуур байрны хүүхдийн хоолны дээжийг тухай бүр мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт төдийлөн гаргуулах боломжгүй зөвхөн дээж авч хадгалаад 48 цагийн дараа устгаж байна. Шалгалтын явцад үдийн цайны амталгаа хийхэд зүсмэл боорцог, хярам тухайн өдрийн цэсийн дагуу Бооржийн хишиг ХХК, Бооржийн урсгал ХХК-тай 3 талт гэрээ байгуулан нийлүүлж гэрээний дагуу санхүүжилтийг бүрэн олгож ажилласан боловч өдөр бүрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад сургуулийн ажилтан албан хаагчдаас санал асуулга авахад сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны амт чанар сайн гэсэн сэтгэл ханамжтай хариулсанаас үзэхэд тогооч нарын ур чадвар сайн дотуур байрны хүүхдийн хоолны чанар сайн байгааг харуулж байна.

2015 онд улсын төсвийн санхүүжилтээр 771,8 сая төгрөг, Яамны хөрөнгө оруулалтаар 74,2 сая төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1059,5 сая төгрөг, ОНХСангаас 5,0 сая төгрөг, НДСангаас 18,8 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 0,8 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны дэвшил гарсан дээрх ололттой талууд байгаа хэдий ч дараах асуудлуудыг сайжруулах шаардлагатай байна.

- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах явцад 2015 оны үдийн цай хөтөлбөрийн хяналт сул, өрсөлдөөн байхгүй зарим талаар шаардлага хангахгүй бүтээгдхүүн нийлүүлж байна. Үдийн цайны санхүүжилтийн зарцуулалт хүүхдийн ирцийн гүйцэтгэлтэй зөрж байгаа нь хүүхдийн ирцийн бүртгэлийг бодитоор бүртгэхгүй байна. Мөн багш, эцэг эхчүүд үдийн цайнд хяналт хийж чанарын бүртгэлийн дэвтэр хөтлөөгүй, чанаргүй, амт сул, цагаасаа хоцорч ирдэг, гар ариутгал ирдэггүй, сав баглаа боодол шаардлага хангахгүй ирж байгаад хяналт тавьж ажиллаагүй байна. Үдийн цайны хэрэгжилтийг жижүүр багшийн ирцийн бүртгэл хөтөлж өдөр тутмын хяналт хийж үр дүнг тооцоогүй, батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж өр үүсгэсэн 1,5 сая төгрөгийн зөрчил гаргасан байна.
- Бараа материалын тооцоо бодоогүй, няравын тайлан шаардлага хангахгүй, нүүрсийг бөөн дүнгээр шууд зарлагдсан, зах зээлийн үнээс дээгүүр үнээр нийлүүлсэн нүүрсний үнийн зөрүү үнэ болох 0,8 сая төгрөг, хүүхдийн хоолны мах зах зээлийн жишиг үнээс дээгүүр үнээр нийлүүлсэн зөрүү үнэ болох 0,6 сая төгрөгийн зөрчлийг төлүүлэх акт, зах зээлийн үнээс дээгүүр үнээр бараа материал нийлүүлж төсвийг үргүй зарцуулахгүй байх 7,6 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.
- Мөн сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг норм нормативаар олгоогүй хэтрүүлэн 2,5 сая төгрөгөөр илүү зарцуулсан зөрчил илэрсэнд холбогдох тогтоол журмын дагуу норм нормативыг мөрдөн ажиллах, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- 2015 онд сургуулийн өмчийн бүртгэлд байгаа цахилгаан моторыг Ховдын өргөө ХХК-нь түр зуур хэрэглэж байгаад одоо хүртэл хүлээлгэж өгөөгүй байгааг ажлын хэсэг томилон шалтгааныг тодруулан байгууллагын хөрөнгийг иж бүрэн болгох.
- 2015 онд төсвөөс 79 орон тоо батлагдсанаас 84 орон тоогоор ажиллаж батлагдсан орон тоог 4 орон тоогоор хэтрүүлэн ажилласан байна. 2015 онд цалингийн сан 587,4 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 597,1 сая төгрөг зарцуулж 5,1 сая төгрөгөөр цалингийн санг хэтрүүлэн зарцуулж бодит бус өр үүсгэсэн байгаа зөрчилд дахин давтахгүй байх зөвлөмж өгч багшийн хэрэгцээ, хүүхдийн тоотой уялдуулан шаардлагатай албан тушаалыг нягтруулж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Тус сургууль нь 2015 онд сургуулийн дунд боловсрол олгох үндсэн зорилгоо ханган ажилласан боловч хүүхдийн хоолны нормыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулж үдийн цай хөтөлбөрт тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар 18,1 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнээс зах зээлийн үнээс дээгүүр үнээр материал нийлүүлж төсвийн үргүй зардал гаргасан 1,4 сая төгрөгийн акт, 7,6 сая төгрөгийн албан шаардлага, цалингийн сан хэтрүүлэн зарцуулсан, үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байгаа, дотуур байрны хүүхдийн хоолыг төсвөөс хэтрүүлэн зарцуулсан бодит бус өр үүсгэсэн байгаа 9,1 сая төгрөгийн зөвлөмж бичлээ.



2.2 . Сумын хүүхдийн цэцэрлэгийн талаар:

Хүүхдийн цэцэрлэг нь 2015 онд “Бид өдөр бүр шинэ, өдөр бүр баяр баясгалантай тоглонгоо хөгжих таатай орчинг бүрдүүлж өөртөө итгэлтэй эрүүл иргэнийг төлөвшүүлнэ” зорилт дэвшүүлэн зорилтоо ханган биелүүлэхийн тулд 4 бүлэгт 140 хүүхэдтэйгээр 16 багш ажилтантайгаар сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж явуулжээ.

2015-2016 оны хичээлийн жилд багш нарыг мэдлэг мэргэжлийг Боловсрол соёлын газраас 4 удаа сургалтанд хамруулсан байна. Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Ном”, “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилгоор “бяцхан мисс” “Уран жиргээ”, урлагын тоглолт дугуйлан секц, дээлний баяр, төрсөн өдрийн баяр даамны дугуйлан, биеийн тамирын тэмцээн, “Бяцхан жентельмен” тэмцээн уралдаануудыг соёлын төвд зохион байгуулжээ. Мөн эцэг эхчүүдэд байгууллагын жилийн эцсийн тайлан, багш нарын тайлан, ажилчидын тайланг сумын соёлын төвд тавьж хэлэлцүүлэн санал асуулгыг авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар гар бөмбөгийн тэмцээн, АХА, тэмцээн, эцэг эхийн сургалтууд, эцэг эхийн нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж явуулсан байна.

Мөн хүүхдийн сурч хөгжих, сургалтын орчинг бүрдүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэ барилга баригдаж ашиглалтанд орсон, төсөл хөтөлбөрт хамрагдан зөөлөн эдлэл, хүүхдийн тоглоом, хөгжим, гал тогооны тоног төхөөрөмжөөр хангаж ажиллажээ.

Төсвийн ерөнхийлэн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж оны эцэст дүгнүүлж 84 хувиар биелүүлж “В” үнэлгээ авчээ.

Төсвийн захирагч 15 багш ажилчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ хийж ажлынх нь үр дүнг тооцож зохих урамшуулалыг олгон ажилласан байна.

Тус цэцэрлэг нь төвлөрсөн төсвөөс 185,2 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 181,4 сая төгрөг авч батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна. 2015 онд тус цэцэрлэг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 615,9 сая төгрөгийн барилга, БСШУЯамны санхүүжилтаар 178,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 20,8 сая төгрөгийн тавилга эд хогшил ирсэн байна.

Илрүүлэлт

- НИК, Хөрс шатахуун түгээх станцуудаас 2015 онд байгууллагын хэрэгцээнд 3,4 сая төгрөгийн шатахуун авсан боловч тайлан гаргаагүй шууд зардалд бүртгэсэн байна.
- Ажилчидын амралт цалинг давхардуулан олгосон зөрчил илэрсэн тул 145619 төгрөгийн төлбөрийн акт бичлээ.



Аудитын тайлан

- 2014 онд туслах багшаар ажиллаж байсан багш нарт ЗГ-ын 90 дүгээр тогтоол олгоогүйтэй холбоотой 878,960 төгрөгийн буцаан олгох төлбөрийн акт бичигдлээ.
- 2016 оны 6 дугаар сард багш ажилчид 4 хоногийн цалин олгоогүй гэсэн өргөдөл ирснийг шалган үзэхэд ажилласан нь баримтаар нотлогдохгүй байна.
- 2015 онд нүүрсийг зах зээлийн ханшнаас өндөр үнээр худалдан авсан тул 105 тн нүүрсний үнэд 360,000 төгрөгийн төлбөрийн акт бичигдлээ.
- Гэрээт ажилчдын нийгмийн даатгалын шимтгэлийг ажиллаагүй хугацаанд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон төлөөгүй байна.
- Багш нарын амралтын цалинг нийгмийн даатгалын программд оруулахдаа тухайн сард ногдох ажлын хоногт нь тооцон оруулаагүй байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад нийт 1,384,579 төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнээс 505,619 төгрөгийн төлбөрийн төсөвт төвлөрүүлэх акт, 878960 төгрөгийн буцаан олгох төлбөрийн акт бичигдсэн тул дахин дээрхи дутагдлыг давтан гаргахгүй байх талаар үүрэг өгөв.

Дүгнэлт: Тус цэцэрлэг нь 2015 онд сургуулийн өмнөх боловсрол олгох үндсэн зорилгоо ханган ажилласан байна.

2.3. Сум дундын эмнэлэгийн талаар: Тус эмнэлэг нь 2015 онд 27 орон тоотойгоор “Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг мэргэжил, ур чадварын өндөр түвшинд үзүүлж, эмнэлэгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж, ажлын байрандаа хөрвөх чадвартай боловсон хүчнийг төлөвшүүлж, зонхилон тохиолдох өвчлөл эрсдлийг бууруулж, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлж, эрүүл биетэй саруул ухаантай өв тэгш хүнийг бий болгох” гэсэн зорилт дэвшүүлж, сумын эмнэлгийн стандартыг хангах гэсэн зорилт тавин ажиллажээ.

Тавьсан зорилтоо хэрэгжүүлэхийн тулд 2015 онд давхардсан тоогоор 4434 хүнд амбулаторийн үзлэг хийж, 2285 ор хоног ашиглаж, 314 хүн хэвтэн эмчлүүлж, багаас ирсэн 946 дуудлаганд явж үйлчилгээ үзүүлсэн, ажилчин нэг бүртэй үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ хийж жилийн эцэст дүгнэн, төсвийн захирагч Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулаагүй, оны эцэст үр дүнгийн гэрээгээ дүгнүүлээгүй байна. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийт 22 хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж 1240 хүнийг сургалтанд хамруулсан байна.

2015 онд эмнэлгийн үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс 350,2 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,9 сая бүгд 352,1 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр улсын төсвөөс 345,1 сая төгрөгний санхүүжилт авч өөрийн



Аудитын тайлан

орлогоор 0,6 сая төгрөг анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Илрүүлэлт:

- Тус байгууллагын ажилчдаас авсан нэргүй санал асуулгаар “Үр дүнгийн урамшууллыг олгодоггүй, байгууллагын дарга, дүн бүртгэгч, нягтлан бодогч нар өөртөө илүү үр дүнгийн нэмэгдэл авдаг, галч, тогооч, асрагч нарт илүү цагийн нэмэгдэл олгодоггүй” гэсэн гомдлын дагуу шалгаж үзэхэд МУ-ын Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолын дагуу дүгнэж олгосон ч байгууллагын дарга нь төсвийн шууд захирагчийн холбогдох тушаал шийдвэргүйгээр 554,850 төгрөгийн үр дүнгийн нэмэгдэл олгосонд албан шаарлага бичигдлээ.
- Бараа материалын тайланг шалгаж үзэхэд нүүрс, мах зэргийг Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан жишиг үнийг мөрдөөгүйтэй холбоотой 1,200,200 төгрөгийн төлбөрийн акт бичигдлээ.

Гүйцэтгэлийн аудитаар 1,755,050 төгрөгийн төгрөгийн төлбөр зөрчил илэрснээс 1,200,200 төгрөгт төлбөрийн акт, 554,850 төгрөгт зөрчлийн барагдуулах албан шаардалага бичигдлээ.

Дүгнэлт:

Тус сумын эмнэлэг нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ биелүүлэн дэвшүүлсэн зорилтоо ханган биелүүлсэн боловч үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрэн бүрдүүлээгүй, бараа материалыг СТСХ-ээс сар бүр гаргадаг жишиг үнээс өндөр үнэтэй бэлтгэсэн байна.

2.4. Соёлын төвийн талаар:

Тус сумын соёлын төв нь 2015 онд эрхлэгч, хөгжмийн багш, бүжгийн багш, номын санч, үйлчлэгч, галч гэсэн 8 орон тоотойгоор нь төрөөс соёлыг хөгжүүлэх талаар баримтлаж буй бодлого, Засгийн газрын хөтөлбөр, Засаг даргын мөрийн хөтөлбөрт соёл урлагийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Соёлын төвийн ерөнхий менежер 2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж үр дүнгийн гэрээгээ 82,3 хувиар ханган биелүүлэн “В” үнэлгээ авсан байна.

Тус байгууллага нь 2015 онд 52,4 сая төсвөөс урсгал санхүүжилт авахаас, 54,2 сая төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогоор 5,0 сая төгрөгийн орлого орохоос 0,6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн өөрийн орлогын төлөвлөгөөг 4,4 сая төгрөгөөр тасласан байна.

Мөн сумын Орон нутгийн хөгжлийн сангаар 3,0 сая төгрөгийг авч орон нутгийн музей тохижуулах болон хөрөнгө худалдан авахад зарцуулсан байна.



Аудитын тайлан

2015 онд Соёлын төв нь соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх, уран сайханчид болон ардын авъяастнуудын хүрээнд шинээр концерт найруулан тоглолт хийх, нийтийн цэнгээнт бүжиг явуулах, алдар тэмдэглэх, үдэшлэг уулзалт зохион байгуулах, хөдөөгийн багуудаар урлаг соёлын арга хэмжээг нийт 45 удаа явуулж давхардсан тоогоор 6518 хүн хамрагдсан байна.

Илрүүлэлт:

- Нүүрсийг жишиг үнийн судалгааг баримтлан аваагүйтэй холбоотой 210,000 төгрөгийн төлбөрийн акт бичлээ.
- Өөрийн орлогын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллаагүй, үнэт цаасны тооцоо бодоогүй байна.

Гүйцэтгэлийн аудитын явцад нийт 210,000 төгрөгийн төлбөр зөрчил илэрсэнээс 210,000 төгрөгийн төлбөрийн төсөвт төвлөрүүлэх акт бичигдсэн тул дахин дээрхи дутагдлыг давтан гаргахгүй байх талаар үүрэг өгөв.

Дүгнэлт: Соёлын төв нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ бүелүүлэн ажилласан боловч өөрийн орлогын төлөвлөгөөг ханган ажиллаагүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаагаа бүрэн ханган хэрэгжүүлэн ажилласан боловч, орон нутгийн татварын орлогыг бүрэн бүрдүүлээгүй, бараа материалыг өндөр үнээр худалдан авсан байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны бүртгэлд тавих хяналт сул, хүүхэд хүмүүжих хөгжих таатай орчинг бүрдүүлэн ажилласан байна.

ЗӨВЛӨМЖ:

Сумын Засаг дарга С.Баасандорж, ЗДТГ-ын дарга Х.Соёлмаа нарт :

- ✚ Тус сумын хэмжээнд бүртгэлтэй мөртлөө байхгүй байгаа 131 авто тээврийн хэрэгсэл байхгүй мөртлөө татварын төлөвлөгөөнд тусгагдаж байгааг судлаж шийдвэрлэх
- ✚ СХСангаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдээс зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 64,4 сая төгрөгийг төлүүлэн авч дараагийн зээлдэгч нарт олгох
- ✚ Биссет компаниас түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр 1960,0 мянган төгрөг, “Лото-блок” компани сумын төвд зам, гэрэлтүүлэг тавьсан бөгөөд энэ ажлын түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг тус тус төлүүлж сумын орлого болгох
- ✚ Хууль бус 1,9 сая төгрөгний нэмэгдэл цалин авсан алба хаагчдын нэмэгдлийг зогсоох

Сургуулийн захирал М.Алтанбаяр-д :

- Зах зээлийн жишиг үнийг баримтлан ажиллаж дотоод хяналтыг сайжруулах, няравын тайлан тооцоог бүрэн хийж, складайн бүртгэл хөтөлж хэвших,
- Нягтлан бодох бүртгэлийн хуулийг мөрдөн ажиллаж өр төлбөр, бараа материалаа НББОУСтандартын дагуу хөтөлж хэвших



Аудитын тайлан

- Хүүхдийн хоолны амт чанар, хоолны илчлэг, нэр төрөлд анхаарч БСШУСайдын 225/296 тоот тушаалаар баталсан хоолны норм, үндсэн шимт бодисын илчлэгийн хэрэгцээг мөрдөж ажиллах
- Үдийн цай хөтөлбөрийн амт чанар нийлүүлэлтэнд тавих хяналтийг сайжруулж сургуулийн эмч, сургалтын менежерийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх
- Орон тоо цалингийн санг хэтрүүлэн зарцуулахгүй байх, багшийн хэрэгцээ, хүүхдийн тоотой уялдуулан шаардлагатай албан тушаалыг нягтруулж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллах

Цэцэрлэгийн эрхлэгч Б.Амарзаяа-д:

- Байгууллагын тайлан балансыг үнэн зөв илэрхийлж холбогдох байгууллагуудтай тооцоо нийлж өглөг, авлагыг үнэн зөв илэрхийлж байх
- Жолоочийн замын хуудсыг сар бүр бичиж, жолоочийн тооцоог бодуулж шатахууны бичгийг 2 хувь үйлдэж байх
- Бараа материалын тайланг сар бүр бодож нягтлан бодогч баталгаажуулж байх
- Нийгмийн даатгалын байгууллагад хүсэлт өгч нийгмийн даатгалын программд багш ажилчидын цалинг үнэн зөв оруулах
- Жишиг үнийн судалгааг баримтлан төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэн ажиллах
- Аудитын явцад илэрсэн алдааг дахин гаргахгүй ажиллах

Сум дундын эмнэлэгийн эрхлэгч эмч Ж.Пүрэвбаатарт:

- Үндсэн үйл ажиллагааны орлогыг биелүүлэх талаар анхаарах.
- Холбогдох байгууллагаас гаргасан зах зээлийн жишиг үнийн мэдээллийг мөрдлөг болгон ажиллах
- Ажилчдын цагийн бүртгэлийг үнэн зөв гаргаж, гэрээт ажилласадад илүү цагийн хөлсийг олгож ажиллах

Соёлын төвийн эрхлэгч Х.Болд-Эрдэнэ-д:

- Зах зээлийн жишиг үнийг баримтлан ажиллах
- Өөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж өглөгийг барагдуулан ажиллах
- Гэрээт ажилчдын ажиллаагүй хугацаанд цалингийн доод хэмжээгээр Нийгмийн даатгалын шимтгэлийг төлж байх.
- Үнэт цаасны тооцоог бодож хэвших



Аудитын тайлан

Аудитаар нийт 12 883 129 төгрөгний төлбөр зөрчил илэрсэнээс 3761819 төгрөгт актыг аймгийн төсөвт оруулах төлбөрийн акт, 878 960 төгрөгийн буцаан олгох төлбөрийн акт, 8 242 350 төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага бичигдлээ.

ТАЙЛАН:

ХЯНАСАН :

ТАНИЛЦСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	ИТХ-ЫН ДАРГА	Н.ЦОГОО
Л.ГАЛБАДРАХ	ЗАСАГ ДАРГА	С.БААСАНДОРЖ
АУДИТЫН МЕНЕЖЕР	ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	Х. СОЁЛМАА
А.ЦЭЦЭГСҮРЭН	ЭРХЛЭГЧ ЭМЧ	Ж. ПҮРЭВБААТАР
БИЧСЭН : АХЛАХ АУДИТОР	ЗАХИРАЛ	М.АЛТАНБАЯР
Д.ХИШГЭЭ	ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ	Б.АМАРЗАЯА
АУДИТОР:	СОЁЛЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ	
Д. МӨНХТУЛГА		Х.БОЛДЭРДЭНЭ
Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ	САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА	
		Ц.БАТТУЛГА
ШИНЖЭЭЧ:	ТӨРИЙН САНГИЙН ТӨЛӨЛӨГЧ	
Б.ДАМЧУУБАЛЖИР		Б. НЯМАА
	НЯГТЛАН БОДОГЧ	Х.ОТГОННЯМ
	НЯГТЛАН БОДОГЧ	П.БАЯНЗУЛ
	НЯГТЛАН БОДОГЧ	С.УЛЬЯНОВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 33

Ховд хот

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн 2016 оны 11 сарын 01-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дуут, Мөст сумдын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Дуут сумын Засаг дарга Д.Таванцэрэг-д ДААЛГАХ нь:

2.1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх

2.2 Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах

2.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн ханган ажиллах

3. Мөст сумын Засаг дарга С.Баасандорж-д ДААЛГАХ нь:

3.1 Тус сумын хэмжээнд бүртгэлтэй боловч байхгүй байгаа 131 авто тээврийн хэрэгсэл байхгүй мөртлөө татварын төлөвлөгөөнд тусгагдаж байгааг судлаж шийдвэрлэх

3.2 СХСангаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдээс зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 64,4 сая төгрөгийг төлүүлэн авч дараагийн зээлдэгч нарт олгох

3.3 Биссет компани, Лото блок компанийн түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөрийг тооцож төсвийн орлого болгох

3.4 Хууль бус 1,9 сая төгрөгний нэмэгдэл цалин авсан алба хаагчдын нэмэгдлийг зогсоох

4. Гүйцэтгэлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 11 сарын 25-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

П.ГАЛБАДРАХ